



TRAINAIR
PLUS
FULL MEMBER

НИСЭХИЙН СУРГАЛТЫН ТӨВИЙН КАТАЛОГ

 МОНГОЛ УЛС ИРГЭНИЙ НИСЭХИЙН ЕРӨНХИЙ ГАЗАР CIVIL AVIATION AUTHORITY OF MONGOLIA	
ИРГЭНИЙ НИСЭХИЙН СУРГАЛТЫН БАЙГУУЛЛАГЫН ГЭРЧИЛГЭЭ CERTIFICATE OF CIVIL AVIATION TRAINING ORGANISATION	
№ МСAA.141.05	
Байгууллагын нэр: Name of Organisation	ИНЕГ-ын Сургалтын төв Training Center of CAA of Mongolia
Бизнес хаяг: Whose business address	Монгол улс, 17120 Улаанбаатар хот, Хан-Уул дүүрэг, 10 дугаар хороо, Буянт-Ухаа Buyant-Ukhua, 10th khoroo, Khan-Uul district, Ulaanbaatar 17120, Mongolia
<p>Дээр дурдсан байгууллага нь Монголын Иргэний нисэхийн дүрэм ИНД-141-ийн шаардлагуудыг хангасан ба тус гэрчилгээний салшгүй нэг хэсэг болох "Үйл ажиллагааны тодорхойлолт"-д заагдсан сургалтыг явуулах эрхтэй.</p> <p><i>It is hereby certified that the above mentioned organization complies with the requirements of the Mongolian Civil Aviation Regulations Part 141, and is adequate to conduct trainings specified in the attached Operations Specifications which is an integral part of this Certificate.</i></p> <p>Энэхүү гэрчилгээг бусад шилжүүлж үл болно. Түдгэлзүүлэх эсвэл хүчингүй болгосноос бусад тохиолдолд энэхүү гэрчилгээ нь доор заагдсан хугацаа хүртэл хүчинтэй.</p> <p><i>This certificate is not transferable and shall remain in force until specified date of expiry, unless sooner suspended or revoked.</i></p>	
ОЛГОСОН / ISSUED BY:	
Гарын үсэг: Signature	 Олгосон огноо: 2016.05.01 Date of Issue 01.May.2016
Олгосон албан тушаалтан: Position	Ч.Батсайхан / Үнэмлэх гэрчилгээжүүлэлтийн хэлтсийн дарга / Batsaikhan.Ch / Director of personnel licensing /
Энэхүү гэрчилгээ нь This certificate in effect until	2021.05.01 01.May.2021 хүртэл хүчинтэй.

2019

АЭРОДРОМ, ГАЗРЫН ҮЙЛЧИЛГЭЭ



**АЭРОДРОМЫН МАНЕВРЛАХ ТАЛБАЙ БОЛОН ПЕРРОНД АЖИЛЛАХ
ЖОЛООЧ- ОПЕРАТОРЧНЫГ МЭРГЭШЛҮҮЛЭХ АНХАН ШАТНЫ СУРГАЛТ**

Сургалтын төрөл: Танхимын сургалт
Сургалтын үргэлжлэх хугацаа: 4 өдөр /32 цаг/
Сургалтын зорилго:

Суралцагчдад аэродромын маневрлах талбай болон перрон дээр тээврийн хэрэгслээр технологийн дагуу хөдөлгөөн үйлдэх аюулгүй ажиллагааны мэдлэг олгох, богино долгионы станц ашиглах, агаарын хөлөгт хөндлөнгийн хүчин зүйлсээс үүсч болзошгүй ослын үед аюулын тархалтыг хязгаарлаж, аюулаас урьдчилан сэргийлэх мэдлэг чадвар эзэмшүүлж, Олон улсын иргэний нисэхийн байгууллага /ИКАО/-ийн Annex-14, IATA-ийн 630.8 дугаар зүйл, 611.6 дугаар зүйлийн стандарт шаардлагын дагуу гэрчилгээжсэн жолооч-операторчныг бэлтгэхэд оршино.

Сургалтад хамрагдах албан хаагч, ажилтнууд:
- Газрын тусгай үйлчилгээний ажилтнууд

**АЭРОДРОМЫН МАНЕВРЛАХ ТАЛБАЙ БОЛОН ПЕРРОНД АЖИЛЛАХ
ЖОЛООЧ- ОПЕРАТОРЧНЫГ МЭРГЭШЛҮҮЛЭХ ДАВТАН СУРГАЛТ**

Сургалтын төрөл: Танхимын сургалт
Сургалтын үргэлжлэх хугацаа: 3 өдөр /24 цаг/
Сургалтын зорилго:

Суралцагчдад аэродромын маневрлах талбай болон перрон дээр хөдөлгөөн үйлдэх, цаг агаарын хүндрэлтэй нөхцөлд үүсч болзошгүй эрсдэлээс урьдчилан сэргийлэх, богино долгионы станц ашиглах аюулгүй ажиллагааны мэдлэгийг сэргээж агаарын хөлөгт хөндлөнгийн хүчин зүйлсээс үүсч болзошгүй аюулаас урьдчилан сэргийлэх мэдлэг чадварыг сайжруулж, Олон улсын иргэний нисэхийн байгууллага /ИКАО/-ийн Annex-14-ийн 9.7-р зүйл, IATA-ийн 630.8 дугаар зүйл, 611.6 дугаар зүйлийн стандартад нийцүүлэн жолооч-операторчныг давтан сургахад оршино.

Сургалтад хамрагдах албан хаагч, ажилтнууд:
- Газрын тусгай үйлчилгээний ажилтнууд

**НИСЭХ БУУДЛУУДЫН СУМЛАГЧ АВТОМАШИНЫ ЖОЛООЧ НАРЫГ
МЭРГЭШҮҮЛЭХ ДАВТАН СУРГАЛТ**

Сургалтын төрөл: Танхимын сургалт
Сургалтын үргэлжлэх хугацаа: 6 өдөр /42 цаг/
Сургалтын зорилго:

Нисэх буудлуудын сумлагч автомашины жолооч нарын мэдлэг чадварыг дээшлүүлж, үүсч болзошгүй аюулаас урьдчилан сэргийлж, агаарын хөлгийг шатахуунаар цэнэглэх үйл ажиллагааг тасралтгүй хийх, нислэгийн аюулгүй ажиллагааг ханган, олон улсын стандарт шаардлагад нийцсэн үйлчилгээг чанартай хийж гүйцэтгэж сурахад оршино.

Сургалтад хамрагдах албан хаагч, ажилтнууд:
- Газрын тусгай үйлчилгээний ажилтнууд

**АГААРЫН ХӨЛӨГТ МӨСТӨЛТИЙН ЭСРЭГ/ХАМГААЛАХ ШИНГЭН
ЦАЦАХ ТУСГАЙ ЗОРИУЛАЛТЫН АВТО МАШИНЫ ИНЖЕНЕР-ЖОЛООЧ,
ОПЕРАТОРУУД БОЛОН ГАЗРЫН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ АЖИЛТНУУДАД
ЗОРИУЛСАН СУРГАЛТ**

Сургалтын төрөл: Танхимын сургалт

Сургалтын үргэлжлэх хугацаа: 4 хоног /32 цаг/

Сургалтын зорилго:

Суралцагч нь агаарын хөлгийн бүтэц зохион байгуулалт, мөстөлтийн эсрэг/хамгаалах шингэний шинж чанар, ашиглалт, аюулгүй ажиллагаа болон шингэн цацах технологийн үйл ажиллагаа, агаарын хөлөгт мөстөлтөөс үүсч болзошгүй аюулаас урьдчилан сэргийлэх мэдлэг чадварыг дээшлүүлж, Олон улсын иргэний нисэхийн байгууллагаас /ИКАО/ гаргасан АНМ-ын зөвлөмж 630.8-д тавигдах шаардлагуудыг хангана.

Мөн үүний хамт Олон улсын иргэний нисэхийн байгууллагаас /ИКАО/ гаргасан Annex-6 дүрмийн “Ground icing” бүлэг, мөн “Газарт мөстөлтөөс хамгаалах” Doc 9640 зааврын талаар мэдлэгтэй, нислэгийн аюулгүй ажиллагааг бүрэн хангаж ажиллах чадвар бүхий инженер техникийн болон газрын үйлчилгээний ажилтнууд бэлтгэгдэх юм.

Сургалтад хамрагдах албан хаагч, ажилтнууд

- Аэродромын талбай дээр хөдөлгөөн үйлдэх ажилтнууд

**АЭРОДРОМЫН АЮУЛГҮЙ АЖИЛЛАГАА ХАНГАХ АЖИЛТНУУДЫН СОНОР
СЭРЭМЖИЙГ ДЭЭШЛҮҮЛЭХ
СУРГАЛТ**

Сургалтын төрөл: Танхимын сургалт

Сургалтын үргэлжлэх хугацаа: 3 хоног /24 цаг/

Сургалтын зорилго:

Суралцагч нь аэродромын хөдөлгөөнт бүсэд агаарын хөлгийн газрын хангалт үйлчилгээний автомашин тоног төхөөрөмжүүдэд хяналт тавих онцгой байдлын болон гэнэтийн ослын үед ажиллах, үзлэг шалгалт хийх, цаг агаарын хүндрэлтэй нөхцөлд үүсч болзошгүй эрсдэлээс урьдчилан сэргийлэх, хувь хүний аюулгүй ажиллагааны мэдлэг, чадвартай IATA-ийн АНМ-611, 630-д нийцсэн ажилтан бэлтгэх зорилготой.

Сургалтад хамрагдах албан хаагч, ажилтнууд

- Газрын үйлчилгээний ажилтнууд

**ОРОН НУТГИЙН НИСЭХ БУУДЛЫН ШАТАХУУНЫ
НЯРАВ-ЛАБОРАНТУУД ЗОРИУЛСАН
СУРГАЛТ**

Сургалтын төрөл: Танхимын сургалт

Сургалтын үргэлжлэх хугацаа: 64 цаг

Сургалтын зорилго:

Нислэгийн аюулгүй ажиллагааг хангах зорилгоор агаарын хөлгийн түлшийг газрын тосны бүтээгдэхүүний хангамжийн технологи, үйл ажиллагааны аргачлал MNS 463352006 стандарт шаардлагын дагуу хүлээн авах, агаарын хөлгийг сумлах, технологи

үйл ажиллагааны үеийн чанарын хяналтын шинжилгээг гүйцэтгэх чадварыг онолын болон дадлагын хичээлээр бататган олгоно.

Сургалтад хамрагдах албан хаагч, ажилтнууд:

- Орон нутгийн нисэх буудлуудын шатахууны нярав лаборантууд

АЭРОДРОМЫН ҮЙЛ АЖИЛЛАГАА

Сургалтын төрөл: Танхимын сургалт
Сургалтын үргэлжлэх хугацаа: Анхан шат 42 цаг, давтан 56 цаг
Сургалтын зорилго:

Суралцагчид нисэхийн аэродромын үйл ажиллагааны анхан шатны мэдлэгтэй болж, давтан суралцагчдад ажил үүргээ гүйцэтгэхэд шаардлагатай мэдлэг, ур чадвар, хандлагыг дээшлүүлэх, сэргээхэд оршино.

Сургалтад хамрагдах албан хаагч, ажилтнууд
- Аэродромын үйл ажиллагааг хариуцсан ажилтнууд

АЭРОДРОМ ТАЛБАЙ БОЛОН АГААРЫН ХӨЛГИЙН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ БҮСЭД ТУСГАЙ ЗОРИУЛАЛТЫН АВТОМАШИН, ТОНОГ ТӨХӨӨРӨМЖИЙН ЖОЛООЧ-ОПЕРАТОРЧИНЫГ МЭРГЭШҮҮЛЭХ СУРГАЛТ

Сургалтын төрөл: Танхимын сургалт
Сургалтын үргэлжлэх хугацаа: 32 цаг
Сургалтын зорилго:

Суралцагчийн аэродром талбай, агаарын хөлгийн үйлчилгээний бүсэд тусгай зориулалтын автомашин, тоног төхөөрөмжөөр технологийн дагуу хөдөлгөөн үйлдэх цаг агаарын хүндрэлтэй нөхцөлд үүсч болзошгүй гэнэтийн ослоос урьдчилан сэргийлэх, богино долгионы радио станц ашиглах, аюулгүй ажиллагааны мэдлэгийг сэргээж, агаарын хөлөгт хөндлөнгийн хүчин зүйлээс үүсч болзошгүй осол, зөрчлөөс урьдчилан сэргийлэх мэдлэг чадварыг сайжруулан олгох юм.

Сургалтад хамрагдах албан хаагч, ажилтнууд:
- Аэродромын талбай дээр хөдөлгөөн үйлдэх ажилтнууд

АЭРОДРОМЫН АЮУЛГҮЙ АЖИЛЛАГААГ ХАНГАХ АЖИЛТНУУДЫН СОНОР СЭРЭМЖИЙГ ДЭЭШЛҮҮЛЭХ МЭДЭЭЛЛИЙН СУРГАЛТ

Сургалтын төрөл: Танхимын сургалт
Сургалтын үргэлжлэх хугацаа: 3 хоног /24 цаг/
Сургалтын зорилго:

Суралцагч нь аэродромын хөдөлгөөнт бүсэд агаарын хөлгийн газрын хангалт үйлчилгээний автомашин тоног төхөөрөмжүүдэд хяналт тавих онцгой байдлын болон гэнэтийн ослын үед ажиллах, үзлэг шалгалт хийх, цаг агаарын хүндрэлтэй нөхцөлд үүсч болзошгүй эрсдэлээс урьдчилан сэргийлэх, хувь хүний аюулгүй ажиллагааны мэдлэг, чадвартай IATA-ийн АНМ-611ь 630-д нийцсэн ажилтан бэлтгэх.

Сургалтад хамрагдах албан хаагч, ажилтнууд:

- Газрын үйлчилгээний ажилтнууд

АГААРЫН ХӨЛӨГ-ГАЗРЫН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ТЕХНИКЧДИЙН СУУРЬ СУРГАЛТ

Сургалтын төрөл: Танхимын сургалт

Сургалтын үргэлжлэх хугацаа: 4 долоо хоног /160 цаг/

Сургалтын зорилго:

Суралцагчдад газрын үйлчилгээ хийх үндсэн мэдлэгийг олгох, газрын үйлчилгээний техник тоног төхөөрөмж дээр ажиллах дадлага туршлагыг олгож, агаарын хөлөг газрын үйлчилгээний мэргэжлийн мэргэшсэн ажилтнуудыг бэлтгэхэд энэхүү сургалтын зорилго оршино.

Сургалтад хамрагдах албан хаагч, ажилтнууд:

- Газрын тусгай үйлчилгээний ажилтнууд

АГААРЫН ХӨЛӨГ-ГАЗРЫН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ТЕХНИКЧДИЙН ДАВТАН СУРГАЛТ

Сургалтын төрөл: Танхимын сургалт

Сургалтын үргэлжлэх хугацаа: 1 долоо хоног /40 цаг/

Сургалтын зорилго:

Суралцагчдын газрын үйлчилгээ хийх үндсэн мэдлэг, ур чадварыг дээшлүүлж, шинэ техник технологи болон тоног төхөөрөмжийн мэдээллээр хангахад энэхүү сургалтын зорилго оршино.

Сургалтад хамрагдах албан хаагч, ажилтнууд:

- Газрын тусгай үйлчилгээний ажилтнууд

АГААРЫН ХӨЛГИЙГ МАРШАЛИЙН ДОХИОГООР УГТАН АВАХ, ҮДЭН ГАРГАХ АЖИЛТНЫГ ШИНЭЭР БЭЛТГЭХ СУУРЬ СУРГАЛТ

Сургалтын төрөл: Танхимын сургалт

Сургалтын үргэлжлэх хугацаа: 80 цаг

Сургалтын зорилго:

Агаарын хөлгийг угтан авч, үдэн гаргахдаа нислэг техникийн аюулгүй байдлыг бүрэн хангаж ажиллах чадварыг онол, дадлагын хичээлээр бүрэн эзэмшүүлж сургахад оршино.

Сургалтад хамрагдах албан хаагч, ажилтнууд

- Орон нутгийн нисэх буудлын ажилтнуудад

**НИСЛЭГИЙН ЗУРВАС ОРЧИМД ШУВУУ, МАЛ АМЬТНЫ АЮУЛААС
УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ ҮЗЛЭГ, ҮРГЭЭЛЭГ ХИЙХ СУРГАЛТ, ДАДЛАГА**

Сургалтын төрөл: Танхимын сургалт

Сургалтын үргэлжлэх хугацаа: 3 хоног /20 цаг/

Сургалтын зорилго:

Шувуу, мал амьтны аюулаас урьдчилан сэргийлэх, үргээх, шувуу үргээх тоног төхөөрөмжүүдийг ашиглахтай холбоотой мэдлэг, ур чадвар, дадлага олгоход оршино.

Сургалтад хамрагдах албан хаагч, ажилтнууд:

- Шувуунаас сэргийлэх ажилтнууд